110

**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 25 өдөр Дугаар А/547 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07 дугаар “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн тахилгат Алтан хөхий уулын тэнгэрийг тайх тахилгын уламжлал, шинэчлэл, зан үйл болон байгаль, газарзүйн онцлогийг судлах, уулын тэнгэрийг тайх тахилгын ёслолын дэг, ёслол үйлдэх хуваарийг шинэчлэх талаар зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурлын зардалд 13,500,000 төгрөг (арван гурван сая таван зуун мянга)-ийн дэмжлэгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Арга хэмжээ зохион байгуулах зардалд 13,500,000 төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.8-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ДЭЛГЭРСАЙХАН

8400 01 2669
Zah A/547 Bo

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 25-ны өдрийн
А/547 дугаар захирамжийн хавсралт

## АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

| Д/д | Зардлын утга | Тоо, хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Тээврийн зардал Ховд-Мянгад-Ховд | 25 | 400 000 | 400 000 |
| 2 | Урилгаар оролцох эрдэмтдийн онгоцны зардал | 5 | 635000*2 | 6 350 000 |
| 3 | Эрдэм шинжилгээний хуралд захиалгаар хэлэлцүүлсэн илтгэлд өгөх зардал | 5 | 200 000 | 1 000 000 |
| 4 | Өндөр хөхийн овооны чиглэлд эрдэмтэд судлаачдын баг ажиллуулах арга хэмжээ зохион байгуулагдах зардал | 25 | 45 000 | 1 125 000 |
| 5 | Судалгааны явц, гүйцэтгэл, үр дүнгээр баримтат бичлэг, нэвтрүүлэг хийх | 1 | 1 500 000 | 1 500 000 |
| 6 | Өндөр хөхийн эзэн савдгийн дүрийг хэвлүүлэн нийтийн хүртээл болгох | 1000 | 1 000 | 1 000 000 |
| 7 | Төрийн тахилгат Алтан хөхий уулын тахилгын тухай уламжлал, соёлын талаар судалгаа хийх | 1 | 2 000 000 | 2 000 000 |
| 8 | Урилга хэвлүүлэх, цай кофены завсарлага | 25 | 5000 | 125 000 |
| Нийт | | | | 13 500 000 |

-oOo-